



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 05 дугаар  
сарын 30 ны өдөр

Дугаар Хэрг  
1193

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын явцын талаар мэдээлэл хийх болсныг үүгээр уламжилж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

004904

**МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШЛЫН ХӨГЖЛИЙН  
ЕРӨНХИЙ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ЯВЦЫН ТАЛААР  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД  
ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

**Өнөөгийн байдал:**

Өнөөгийн байдлаар Монгол Улсын нийт хүн ам 3.2 саяд хүрч, нутаг дэвсгэрийн хувьд нийслэл, 21 аймаг, 330 сум бүхий засаг захиргааны бүтэц, зохион байгуулалтын нэгжтэй болоод байна.

Манай орон эх газрын эрс тэс уур амьсгалтай, уул, тал хээр, говь цөл хосолсон өргөн уудам нутагтай бөгөөд хүн амын нутагшилт, хот, суурин газрын хөгжил нь уламжлалт нүүдлийн соёл иргэншлээс шууд хамааралтай, нягт уялдаатай байсан учраас дэлхийн бусад орнуудаас өвөрмөц хэдий ч ХХ зууны дунд үеэс суурин амьдрал, хотжилт руу хурдацтай шилжих үе эхэлж, хүн амын дийлэнх хувь томоохон хот, суурин газруудад оршин сууж, уг үйл явц нь улс орны хөгжлийг тодорхойлоход гол нөлөөг үзүүлэх боллоо.

ХХ зууны 30-аад оноос эхлэн аж үйлдвэр, газар тариалангийн салбарыг хөгжүүлж эхэлснээр хүн амд үйлчлэх зориулалттай зам харилцаа, сургууль, эмнэлэг, соёлын газар зэрэг нийгмийн цогц үйлчилгээ бүхий хот, суурин газрыг олноор байгуулах болсон. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд, аймаг, сумын төв болон бусад суурин газрыг үүсгэн хөгжүүлсэн нь монголчуудын амьдралын хэв маягийг суурин соёл иргэншлийн ололтоор баяжуулж, үндэсний эдийн засаг, соёлын дэвшлийг түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирлээ.

Монгол Улсын хүн амын судалгаа, мэдээллээс үзэхэд, хотжилтын түвшин нь хөдөөгөөс хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хурдацтай нэмэгдэж 67.6 хувьд хүрээд байна. Нийслэл, бүсийн тулгуур төв болон аймгийн төв болох 23 хот, түүний орчимд манай улсын нийт хүн амын 60.0 гаруй хувь нь амьдарч ажил хөдөлмөр, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа юм. Тухайлбал, зөвхөн Улаанбаатар хотод манай улсын хүн амын 46 хувь нь төвлөрч, аж ахуйн нэгж, байгууллагуудын 70 орчим хувь нь байршиж, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна.

Энэхүү үйл явцаас хамааралтайгаар сүүлийн жилүүдэд хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгаа гарч, нийслэл хот болон уул уурхай (Эрдэнэт, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций г.м), авто зам, төмөр замын гол тэнхлэг дагасан хот, суурин (Дархан, Сайншанд, Замын-Үүд г.м) газруудын хүн амын өсөлт нэмэгдэж, суурьшлыг тэлэх боллоо.

Хотуудын хүн амын механик өсөлт, эдийн засаг, нийгмийн хөгжил болон бусад холбогдох аж үйлдвэрийн үйл ажиллагаа нэмэгдсэнээр нутаг дэвсгэр, хүн амын нутагшилт, суурьшил дээр томоохон өөрчлөлт орж, иргэдийн амьдралын хэв маяг өөрчлөгдөн, экологийн нөхцөл байдал муудаж байна. Ийм хандлага цаашид ч үргэлжлэх төлөвтэй байгаа нь хот байгуулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлтийг гаргаж, хэрэгжүүлэх шаардлагатайг илэрхийлж байна.

Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоо нь нэг төвтэй болж, зарим талаар нийгмийн эрчимтэй хөгжилд сөрөг нөлөөг үзүүлэх үндсэн шалтгааны нэг болж байна. Тиймээс хүн амыг нутаг дэвсгэртээ оновчтой нутагшуулан суурьшуулах, үүнтэй холбогдож үүсэх олон үндсэн асуудлыг шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ байна.

Манай орны хотжилтын үйл явц 1990-ээд оноос эхлэн эрчимтэй явагдаж, өнөөгийн байдлаар нийт хүн амын дийлэнх хувь нь хот, суурин газруудад оршин суух болсон бөгөөд энэхүү эрчимтэй шилжилт хөдөлгөөний явцыг дагаад ялангуяа том хотуудад хүрээлэн буй орчны доройтол бий болж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа ихсэх, бүс нутгийн тэнцвэрт бус хөгжил, хотын ажилгүйдэл, ядуурал ихсэх, хэт төвлөрөл нэмэгдэх, хотын дэд бүтцийн даац хэтрэх зэрэг нийгэм, эдийн засгийн ихээхэн сөрөг үр дагаврыг бий болгосон.

Дээрх сөрөг нөхцөл байдлыг дэлхий нийтийн хэмжээнд авч үзэхэд манай орноос гадна Мексик, Бразил, Египет, Сенегал, Нигер, Бангладеш, Энэтхэг, Пакистан, Индонези зэрэг улсуудад тулгамдсан асуудал болж, том хотуудын хэт төвлөрлийг сааруулахын тулд бага, дунд хотуудын хөгжлийг дэмжих, мөн шинэ суурьшлын төвүүдийг байгуулах замаар хүн амын тогтвортой хөгжил бүхий нутагшилт, суурьшлын бодлогыг шинээр боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай болоод байна.

Иймд дэлхий нийтээрээ том хот руу шилжин суурьших явдлыг багасгахын тулд аливаа улс орон хөдөөд амьжиргааны нөхцөлийг сайжруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, бүсийн тэргүүлэх төв, дагуул хотуудын хөгжлийг дэмжихийг чухалчлан үзэж, даян дэлхийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх үүднээс Засгийн газраас тусгай бодлого, төлөвлөлтийн урт хугацааны баримт бичгүүдийг батлан гаргаж хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, БНСУ-д “Үндэсний нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлого ба стратеги”, Япон Улсад “Үндэсний төлөвлөгөө”, ОХУ-д “Нутагшилт, суурьшлын ерөнхий схем”, БНТУ-д “Хот, суурин газрын хөгжлийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө бэлтгэх төсөл” хэрэгжиж байгаа юм байна.

Энэхүү хүн амын нутагшилт, суурьшлын бодлогын баримт бичгүүдийг боловсруулан хэрэгжүүлэхийн тулд гадаад улс орнуудад “Хүн амын нутагшилтын институт”, “Хүн амын нутагшилт, суурьшлын судалгааны институт”, “Хот, суурингийн систем төлөвлөлтийн институт”, ГИПРОГОР зэрэг эрдэм шинжилгээ, судалгаа, төлөвлөлтийн чиглэлээр мэргэжлийн байгууллага, хүрээлэнгүүдийг байгуулан ажиллуулдаг.

Хүн амын суурьшлын асуудлаар 1996 онд Стамбул хотод зохион байгуулагдсан НҮБ-ын II их хурлаас нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг хангахад бүс нутгийн хөгжлийг тууштай хэрэгжүүлэх нь тухайн улс орнуудын Засгийн газруудын хүлээх үүрэг гэж тодорхойлсон. Улмаар 2016 онд зохион байгуулагдсан НҮБ-ын III их хурлаас тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжүүлэхээр болоод байна. Үүний дагуу Засгийн газар 2 жил тутамд дэлхийн хотуудын форумд дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, туршлага солилцох үүрэг хүлээгээд байна.

Дээрх олон улсын жишгээс авч үзвэл, манай улсын хувьд хүн амын амьдрах тохиромжтой орон зай, тааламжит орчныг өөрийн орны хөгжиж ирсэн онцлог, газар нутгийн нөөц, баялаг, байгаль, цаг уурын өвөрмөц нөхцөлтэй уялдуулан, цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан газар зүйн байршилд тулгуурлан тодорхойлж, энэ үндсэн дээр нийгэм, эдийн засгийн ирээдүйн хөгжил, соёлын түвшинг илэрхийлэх, нийгмийн дэвшилд идэвхтэй нөлөөлөх бодит үр дагавар бүхий нутаг дэвсгэрийг зохион байгуулах, хүн амыг зохистой байдлаар нутагшуулах төслийг боловсруулж, төрийн бодлогын түвшинд авч үзэн хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

## **Төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:**

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Мөн Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.79-д “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах”-аар тусгасан.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.5 дахь хэсгийн Зорилт 5-д 2016-2020 онд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах, Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлого”-ын баримт бичгийн Стратегийн зорилт 6-д “Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхид нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ”, Улсын Их Хурлын 2014 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 7.2-т “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах”, Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 6.1-д “2017-2030 онд Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах” гэж тус тус тусгагдсан.

Монгол Улсын Үндсэн хуульд “Төр нь үндэсний аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэсэн заасныг хэрэгжүүлэхэд юуны өмнө өргөн уудам нутаг, харьцангуй эмзэг байгаль, цөөн хүн амын харилцан шүтэлцээг харгалзах ёстой. Үүнд, Монгол орны газар нутаг, уур амьсгал, хүн амын уламжлалт нүүдлийн болон суурин хэвшлийн амьдрал, соёл иргэншлийн онцлогт тохирсон шинжлэх ухааны үндэслэлтэй, алс хэтийн хараатай хот байгуулалтын зөв бодлого хэрэгтэй юм.

1992-1995 онд Дэд бүтцийн хөгжлийн яамны харьяа (хуучнаар) байгууллага болох Зураг төсөл, судалгааны үндэсний төвд “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг анхлан боловсруулж байсан. Улмаар 2000 оноос “Хот байгуулалт” ТӨҮГ (хуучнаар)-г Улсын Их Хурал, Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу уг төслийн зарим хэсэгт нь тодотгол хийж байжээ.

Улсын Их Хурлын даргын 2000 оны 49 дүгээр захирамжаар “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг “Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-тай уялдуулан боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажилласан бөгөөд “Улсын дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэг-Мянганы зам болон дэд бүтцийн босоо таван тэнхлэгийн чиглэл”-ийг Улсын Их Хурлын 2001 оны 9 дүгээр тогтоолоор, “Бүсийн тулгуур төв хотууд”-ыг Улсын Их Хурлын 2003 оны 1 дүгээр тогтоолоор тус тус батлуулсан.

Гэвч эдгээр тогтоолд тусгагдсан зорилтот арга хэмжээнүүдийг багтаасан цогц шийдэл бүхий иж бүрэн баримт бичиг болох “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг хамтад нь батлаагүй нь хүн амыг нутаг дэвсгэрийн хэмжээнд

оновчтой нутагшуулан суурьшуулах, үүнтэй холбогдон үүсэх хөгжлийн олон талт асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэхэд бэрхшээл үүсгэсэн.

“Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг анх боловсруулж байсан 1996 оноос хойш Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтолцоонд ихээхэн өөрчлөлт, дэвшил гарсан тул уг төслийн баримт бичгийг шинээр боловсруулах шаардлага бий болсон. Тухайлбал:

-Монгол Улсын хүн ам 3 177 899 болж өссөн (2017 оны жилийн эцсийн байдлаар);

-Малын тоо 66 сая 218 мянгад хүрсэн (2017 оны жилийн эцсийн малын тооллогын дүнгээр);

-Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 5.1 хувь (2017 оны байдлаар) болсон;

-Уул уурхайн болон барилгын салбарт өсөлт бий болж, Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн ордуудаас гадна уул уурхайн ордууд нээгдэж, тэдгээрийг дагасан хот, суурин байгуулагдаж байна.

-Хөшигийн хөндийд баригдсан олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн шинэ суурьшил, хот суурин үүсэх нөхцөл байдал бүрдэх боллоо.

-Монгол Улсын бүх аймгийн төвүүд нь нийслэл хоттой хатуу хучилттай замаар холбогдсон, мөн уул уурхай, аж үйлдвэрүүдийг холбосон зам, тээврийн сүлжээ (төмөр зам, хурдны зам)-г барих ажлыг эхлүүлээд байна.

-Зарим бүс нутгийг газар тариалангийн чиглэлээр хөгжүүлснээр өөрийн орны дотоод хэрэгцээг бүрэн хангах боломж бүрдэж байна.

-Гадаад болон дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх шинэ чиглэл, маршрут гарч, бүс нутгийг хамарсан шинэ цогцолбор төслүүдийг хэрэгжүүлэх болсон. Үүнийг дагасан аялал жуулчлал, үйлдвэрлэл, үйлчилгээний төвүүд бий болно.

-ОХУ, БНХАУ-тай хил орчмын хамтын ажиллагаа идэвхжиж, хилийн боомтууд шинээр нээгдэж, байнгын үйл ажиллагаатай боомтуудын тоо нэмэгдэх болсноор хил орчмын суурьшлын бүсүүд бий болох хандлагатай байна.

-Дэлхийн байгаль, цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор улс орны хэмжээнд “ухаалаг” болон “ногоон” хөгжлийн асуудлыг шинээр авч үзэж, нутагшилт, суурьшлын төсөлд тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

-Нийслэлийн хэт төвлөлийг сааруулах, орон нутагт хөгжлийг бий болгож, хүн амыг тогтвортой суурьшуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаатай холбогдуулан шинэ бодлого, төлөвлөлт шаардлагатай байна.

Үүний зэрэгцээ дэлхийн уур амьсгалын өөрчлөлт нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал, 1940-2010 онд дэлхийн түвшинд дулаарал  $+0.85^{\circ}\text{C}$  байхад Монгол оронд  $+2.07^{\circ}\text{C}$  буюу дэлхийн дунджаас 2.4 дахин их байгаа бөгөөд улмаар Монгол Улс уур амьсгалын эрсдэлд эмзэг байдлаар дэлхийн 100 гаруй орноос 8 дугаарт орж байна.

Манай оронд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө нь усны нөөц, горимд өөрчлөлт орох, олон жилийн цэвдэгт хөрс болон өндөр уулын мөстлөг хайлах, нуур цөөрөм, булаг шанд ширгэх, хөрсний усны түвшин доошлох, зуны хэт халалт, хуурайшилт болон агаарын мандлын гаралтай конвекцийн үзэгдлийн улмаас хөрс, бэлчээр доройтон ургамлын төрөл зүйлийн бүрдлийн тоо цөөрч, цөлжих үйл явц идэвхжих, зэрлэг амьтдын тархалтын бүс нутаг өөрчлөгдөх, ой хээрийн түймрийн давтагдал нэмэгдэх зэргээр илэрч байна.

Монгол орны өргөн уудам газар нутагт хүн амын нутагшилт, суурьшлын орон зайн төлөвлөлтийг өнгөрсөн 70 гаруй жилийн уур амьсгалын өөрчлөлт, цаашдын хандлагатай уялдуулан авч үзэх нь хот, суурин газрын тогтвортой хөгжлийг хангах, уур амьсгалын

өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дасан зохицох үндсэн нөхцөл болно.

Өнгөрсөн 70 гаруй жилийн хугацаанд орон зайн хувьд уур амьсгалын өөрчлөлт 20С-ээс дээш дулаарч буй бүсэд Улаанбаатар болон 9 хот, 55 сумын төв оршиж байна. Энэхүү бүсэд нийт хүн амын 60 хувь амьдарч байгаа нь Монгол Улсын хүн амын дийлэнх хэсэг нь уур амьсгалын өөрчлөлт, дулаарлаас үүдэлтэй эрсдэл өндөртэй бүсэд суурьшиж байгааг харуулж байна.

Түүнчлэн эрчимтэй хотжилт нь зүй бус газар ашиглалтыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт хотуудын эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.

Хуурай, эрс тэс уур амьсгалтай, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг Монгол Улсын хувьд хамгийн их хохирол дагуулдаг байгалийн гамшиг болох ган, зудын давтамж болон хохирлын хэмжээ уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр нэмэгдэж байна. Тухайлбал, 1999-2002 онд болон 2009-2010 онд нийт нутгийн 80-90 хувийг хамарсан ган, зуд дараалан тохиолдсон жилүүдэд олон сая мал зүй бусаар хорогдож, олон мянган малчин өрх малгүй болсон бөгөөд улмаар гамшгийн дараах жилүүдэд хөдөөнөөс хот руу шилжин суурьшсан хүн амын тоо эрс нэмэгдсэн байдаг.

Хот, суурин газрын 75 орчим хувь нь газар хөдлөлтийн Рихтерийн 7 ба түүнээс дээш, 12 сум 9 баллаас дээш газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд, нийт хүн амын 86 хувь нь эдгээр газар нутагт амьдарч байна. 2005 оноос Улаанбаатар хотод 20 км орчим зайд газар хөдлөлтийн идэвхжилт ажиглагдан 6 орчим хагарлыг илрүүлэн судалж байна. Улаанбаатар хот орчимд 2005 онд 1000, 2009 онд 2000, 2010 онд 2500 удаагийн газар хөдлөлтийн чичирхийлэл бүртгэгдсэн.

Уур амьсгалын өөрчлөлт нь нийт Монгол Улсын хүн ам, эдийн засагт эрсдэлтэй, олон сөрөг үр дагаврыг авчрах төлөвтэй байгаа бөгөөд энэ нь ус, ой, бэлчээр, газар, хөрс зэрэг нөхөн сэргээгдэх нөөцийн ашиглалтын менежмент, хүн амын нутагшилт, суурьшил, эрүүл мэндийн үйлчилгээ, технологийн стандартыг сайжруулахыг шаардаж байна.

Монгол Улсын эдийн засагт томоохон хот, суурины үзүүлэх нөлөө жил ирэх бүр нэмэгдсээр байгаа нь эдийн засгийн хөгжлийг орон зайн хувьд тэнцвэртэй хөгжүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Хөдөө аж ахуй, газар тариаланд суурилсан эдийн засгийн бүтцэд өөрчлөлт орж, энэ салбарт ажиллагсдын тоо буурах хандлагатай болсон. Мөн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн уламжлалт мал аж ахуй, газар тариалан нь тогтвортой орших нөхцөл хумигдсаар байна. Үүнтэй холбоотой шилжилт хөдөлгөөн жилээс жилд өсөн нэмэгдэж, хүн амын төвлөрөл цөөн тооны томоохон хот, сууринд бий болсон нь бүс нутгийн хөгжлийн бодлогыг цаг алдалгүй хэрэгжүүлэх, томоохон тулгуур төвүүдийг хоцронгуй бүсүүдэд бий болгох бодит хэрэгцээг үүсгээд байна.

Иймд Монгол орны газар нутаг, байгалийн нөхцөл, нөөц, хүн амын уламжлалт нүүдлийн болон эрчимжиж буй суурин хэвшлийн амьдрал, соёл иргэншлийн зохистой харьцаа, өвөрмөц онцлогт нийцсэн төрийн цогц бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг дунд болон урт хугацааны төлөвлөлт, үзэл баримтлалаар илэрхийлж, түүндээ цаашид байнга тодотгол оруулан боловсронгуй болгож байх нь зүйтэй юм.

Монгол Улсын Үндсэн хуульд "... хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, амрах эрхтэй..." гэж заасан нь бүхэлдээ хот байгуулалтын тухайлбал, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн хүрээнд дараагийн үе шатны бус нутгийн төслүүд болон хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр дамжин хэрэгжиж байх ёстой билээ.

#### **Төслөөр шийдвэрлэх үндсэн асуудлууд:**

Монгол Улсын хүн ам, нийгэм, эдийн засгийн ойрын болон ирээдүйн хөгжлийн зүй тогтлын дагуу хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн зохистой тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн дараах үндсэн асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд:

-Хүн амын нутагшилт, суурьшлын одоогийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, давуу болон сул талыг тодорхойлох;

-Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргааны түвшин, байгалийн нөхцөл, нөөц, цаг уурын нөхцөл зэргийг тооцсоны үндсэн дээр хот, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшилд тохиромжтой нутаг дэвсгэр, бүсүүдийг тогтоох, шинээр бий болох хот, суурин газрын байршил, үүргийг тодорхойлох;

-Монгол орны хөгжлийг тэтгэх зам, тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч зэрэг дэд бүтцийн үндсэн тэнхлэгийг нутаг дэвсгэр зохион байгуулалтын бодлоготой уялдуулж цогцоор хөгжүүлэх, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

-Улсын нутаг дэвсгэр зохион байгуулалтыг оновчтой шийдвэрлэн, хөгжлийн төвүүдийг тодорхойлж, цаашдын хандлагыг тооцож тогтоох;

-Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд болон хот, суурин газруудад хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;

-Амралт, аялал жуулчлал, байгаль хамгаалал, түүх, соёлын асуудлыг хүн амын нутагшилт, хот байгуулалтын бодлоготой уялдуулан тодорхойлох;

-Жижиг, дунд, хүнд үйлдвэрлэл хөгжих нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, хот байгуулалтын нөхцөлийг бүрдүүлэх;

-Нэг төвөөс олон төвт тогтолцоо руу оновчтой шилжих үндэслэлийг боловсруулах, хөгжлийн ирээдүйн төлөвийг тодорхойлох;

-Хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалтын шийдэлд тулгуурласан засаг захиргааны хуваарийн өөрчлөлтийг хийх, санал, зөвлөмжийг боловсруулах зэрэг болно.

#### **Төслийн удирдлага, зохион байгуулалт:**

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Ногоон хөгжлийн бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилтыг хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 5 дугаар тогтоолоор “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулан батлуулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хороог байгуулсан.

Тус хорооноос “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулж батлуулах ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын зургийн даалгаврын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авах, нэгтгэх ажиллагааг явуулж байна.

Мөн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.79.1-д “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын хүрээнд Хот байгуулалт, эрдэм шинжилгээ, зураг төслийн институтийг байгуулж, суурь судалгааны ажлыг гүйцэтгэх” гэж заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвийн дэргэд “Хот байгуулалт, зураг төсөл, төлөвлөлтийн институт”-ийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.

Төслийн хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын орон зайн өгөгдлийн дэд бүтэц, мэдээллийн санг түшиглэн нийт нутаг дэвсгэрийг хамарсан орон зайн төлөвлөлт хийх ажлыг зохион байгуулж байна.

Барилга, хот байгуулалтын яамны хэмжээнд Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох салбарын чиглэлээр судалгаа, тооцоолол, мэдээллээр хангах, санал, зөвлөмж өгөх үүрэг бүхий техникийн ажлын хэсэг байгуулагдсан.

Тус яамнаас өргөн хүрээтэй зөвшилцөл, зөвлөлдөх механизмыг бий болгох зорилгоор холбогдох гадаадын түнш байгууллагуудын төлөөллийг техникийн ажлын хэсэгт оролцуулсан бөгөөд энэ хүрээнд шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах, техник туслалцаа үзүүлэх чиглэлээр НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын хөтөлбөр (НҮБ-ХАБИТАТ)-тэй хамтран ажиллаж байна.


Мөн Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын техник туслалцааны хүрээнд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах суурь судалгааны ажлыг гүйцэтгэх, төслийг боловсруулах хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх” чиглэлээр хамтран ажиллаж байгаа бөгөөд тус байгууллагын Төслийн зөвлөх баг 2018 оны 10 дугаар сараас Монголд ирж ажиллахаар тохиролцоод байна.

Түүнчлэн 2017 оны 10 дугаар сарын 4-ний өдөр Азийн хөгжлийн банк, Барилга, хот байгуулалтын яамны хооронд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлэх зорилгоор харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан болно.

Тус яамнаас төслийг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд эрдэмтэн, судлаачид, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшил зэрэг бүх талуудын оролцоог хангах үүднээс “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулахад эрдэмтэд, судлаачид, мэргэжилтнүүдийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг гурван удаа зохион байгуулсан.

**Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловруулж батлуулах, хэрэгжүүлэх удирдлагын бүтэц, зохион байгуулалтын схем**

Зураг 1



**Төслийг боловруулахаар төлөвлөж буй цаг хугацаа: 2018-2020 он**

**Төслийг боловруулах аргачлал:**

Төслийн аргачлалын гол агуулга нь нийт нутаг дэвсгэр, үндэсний түвшинд байгаа нөхцөл, нөөцийг зөв тодорхойлж, түүнийг илүү үр ашигтай, ухаалгаар ашиглан улс, бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах нийгэм-эдийн засгийн хөгжлийн чиг баримжааг үндэслэлтэй тогтооход оршино.

Төсөлд хот байгуулалтын шинжлэх ухааны түгээмэл хэлбэрүүд тухайлбал, хүн амын нутагшилт суурьшил, бүс нутгийн зохистой тогтолцоо бүрдэх хүчин зүйлүүдийг тооцож, статистик-дүн шинжилгээ, төсөөлөл-магадлал, эрсдэлтийн харьцуулалт, хүн-байгалийн амин шүтэлцээ, шинжлэх ухаан, техник-технологийн хөгжлийн үр дагавар, бодлогын асуудалд тулгуурлан хэсэгчилсэн зорилтуудыг бодитойгоор хэрэгжүүлэх арга зам, нийгмийн дэвшлийн шинэчлэлт, өөрчлөлтийн шинэлэг хандлага, нийгмийн сэтгэлгээ, оюуны санааны эрэлт хэрэгцээ зэрэг цогцолбор асуудлуудтай харилцан уялдаатайгаар авч үзэх болно.

**Төслийн судалгаа, шинжилгээ, харьцуулалт дүгнэлт:**

Өнөөгийн Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоо, чиг хандлагад анализ судалгааг хийж, хөгжлийн давуу болон сул тал, нөөц боломжийг тооцсоны үндсэн дээр тогтвортой хөгжлийг хангах стратегийн зорилтыг тодорхойлно.

Үндэсний нутагшилт, суурьшлын тогтолцоонд хүн ам, эдийн засагт эзлэх байр сууриас хамааралтай Улаанбаатар хотын үзүүлэх гол хүчин зүйлүүдийн нөлөөллийг нарийвчлан судална.

Төрөөс баримтлах бодлогын хүрээнд урьд нь бүсчлэл, бүс нутаг болон хот, суурины хөгжил, бусад салбаруудын чиглэлээр хийгдсэн төслүүдийн шийдэл, хэрэгжилтийн байдал, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалт, уламжлалт соёл, иргэншлийн өөрчлөлт, шинэчлэлийг хот байгуулалт, хүн ам, хөдөлмөрийн нөөц, үйлдвэрлэх хүчин, мал аж ахуй, газар тариалан, байгаль орчин, нийгэм-эдийн засгийн салбарын хөгжлийн шинэ харилцааны нийтлэг шаардлага, зорилтуудтай харьцуулан дүгнэх болно.

Мөн олон улсын байгууллага болон бусад орнуудын ижил төстэй бодлогын чиглэл, баримт бичиг, туршлагыг судлан үзэж, мэдээлэл болгон ашиглана.

### **Төслийн үр дүн:**

-Хүн амын нутагшилт, суурьшлын талаар төрөөс баримтлах урт хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй болно.

-Бодлогын түвшинд богино (3-5 жил хүртэл), дунд (8-10 жил), урт (15-20 жил хүртэл) хугацаанд хэрэгжүүлэх стратегийн зорилтуудыг тодорхойлно.

-Хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоо болон нутаг дэвсгэр зохион байгуулалтын нэгдсэн схемийг боловсруулна.

-Бүс нутаг, хот, суурин газруудын хөгжлийн чиглэл, гүйцэтгэх үүргийг тодорхой болгож тогтооно.

-Үндсэн дэд бүтэц (зам, тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч г.м), аж үйлдвэрлэл, уул уурхай, аялал жуулчлал, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хот байгуулалтын бодлоготой уялдуулан цогц төлөвлөлтийг боловсруулна.

### **Шийдвэрлэх шаардлагатай зарим асуудал:**

-Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар баталсан улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах арга хэмжээг Барилгын хөгжлийн төвийн ТӨҮГ-ын “Хот байгуулалт, зураг төсөл, төлөвлөлтийн институт”-ээр гүйцэтгүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх;

-Төслийг боловсруулахад шаардагдах төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган, батлуулах;

-Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулах үйл явцыг Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагаатай нягт уялдуулан боловсруулах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР